

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говь-Алтай аймгийн Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2023/87/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2021 он	Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484030 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn “Анализ старт аудит” ХХК-ийн Ахлах аудитор А.Батжаргал Утас: 99291595 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ДАРИВ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА Н.ЦОГДЭЛГЭР ТАНАА

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2022.04.06 № 103

танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Говь-Алтай аймгийн Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Говь-Алтай аймгийн Дарив сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар амралтын цалинг илүү олгосон, хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр урамшуулал олгосон, улирлын үр дүнгийн урамшууллыг дутуу олгосон, нийгмийн даатгалын тайланг илүү тайлагнасан, аж ахуйн нэгж байгууллагатай тооцоо нийлсэн акт үйлдээгүй зэрэг 16.3 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр баталсан. Энэ хуулиар байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 43 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 91.25 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

0702000238

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/мянган. төгрөг/

	Үзүүлэлт	2022.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	82,859.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	397,428.3
	Нийт хөрөнгийн дүн	480,287.9
	Нийт өр төлбөрийн дүн	0.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	480,287.9
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	480,287.9
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	786,168.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	362,422.5
	Үйл ажиллагааны үр дүн	423,746.2
	Үйл ажиллагааны бус үр дүн	0.00
	Үйл ажиллагааны нийт үр дүн	423,746.2
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	56,541.7
	Тайлант оны үр дүн	423,746.2
	Эцсийн үлдэгдэл	480,287.9
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	381,869.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	366,456.9
	Үйл ажиллагааны ЦМГ	15,412.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(15,077.0)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	0.0
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	335.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	335.4
Төсвийн гүйцэтгэлийн тайлан УТ		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	367,793.9
	Урсгал зардал	367,793.9
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	367,703.1
	Эрүүл мэндийн даатгалын сангаас	298,070.6
	Туслах үйл ажиллагааны орлогоос	68,632.5
	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл	355.4
Төсвийн гүйцэтгэлийн тайлан ОН		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	13,654.5
	Урсгал зардал	13,654.5
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	13,654.5
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	13,654.5

Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 125.3 сая төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитаар залруулсан. Үүнд:

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Үндсэн хөрөнгийг 93.7 сая төгрөгөөр илүү тайлагнасан, авлагыг 0.3 сая төгрөгөөр илүү тайлагнасан, харилцах данс хоорондын гүйлгээг орлого, зарлага хийгдсэн байдлаар илэрхийлсэн алдаа гаргасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

Аудитаар нийт 66.2 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 11.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, сахилгын шийтгэл оногдуулах 1 заалт албан шаардлага, 54.4 сая төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 7 заалт албан шаардлага, хуулийн хэрэгжилт хангах 1 заалт зөвлөмж хүргүүлсэн.

3.1 Төлбөрийн акт

- ✓ Амралтын цалинг үндсэн цалинтай давхардуулан 0.9 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгоход төсвөөс 9.9 сая төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", 15.1.5-т "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"; Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолын 5 дугаар зүйлийн 5.4.-т "бүх шатны төсвийн байгууллагын гадаад албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах болон хэвлүүлэх, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, салбарын болон байгууллагын тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, салбартай холбоотой киноны уран бүтээл хийх, төрийн захиргааны төв байгууллагуудын тээвэр, шатахууны зардал, төрийн тусгай чиг үүргийн байгууллагаас бусад төрийн байгууллагууд шинээр автомашин худалдан авах зардал, захиргааны албан контор шинээр барих зардлыг тус тус 100 хувь, бүх шатны төрийн байгууллагын бичиг хэргийн зардлыг 50 хувь, коронавируст халдварын цар тахалтай тэмцэж байгаа эрүүл мэнд, онцгой байдал, цагдаа, мэргэжлийн хяналт, хил, гаалийн байгууллагаас бусад бүх шатны төрийн байгууллагын дотоод албан томилолтын зардлыг 50 хувь тус тус хэмнэх чиглэл баримтлах" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

- ✓ Үр дүнгийн урамшууллыг 1.1 сая төгрөгөөр дутуу олгосон, өглөг үүсгээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.10-т "Эрүүл мэндийн байгууллагын тасаг, нэгжийн хамт олны хурлаас гаргасан дүгнэлтийг үндэслэн эрүүл мэндийн ажилтанд мөнгөн урамшил олгох шийдвэрийг байгууллагын дарга гаргана" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Хариуцлага тооцох албан шаардлага

- ✓ Жилийн эцсийн тооллогын комисс батлаагүй, тооллого хийгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө;/, 20.2.6-т /эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;/, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.3 Албан шаардлага

- ✓ Нийгмийн даатгалын тайланд ажилчдын 2.1 сая төгрөгийн цалинг илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга /тэмдэг/ дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна", Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", Сангийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 246, А/245 дугаар хамтарсан тушаалын 2 дугаар хавсралт" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 21.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй шатахууны зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- ✓ Тендерт шалгараагүй аж ахуйн нэгж байгууллагаас 9.3 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл худалдаж авсан нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно." заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Байгууллагаас и-баримтгүй 19.4 сая төгрөгийн бараа ажил үйлчилгээний худалдан авалт хийсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Аж ахуйн нэгж байгууллагатай 2.5 сая төгрөгийн өглөгийн тооцоо нийлсэн актгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Тус байгууллага нь нэгдсэн халаалтын системд холбогдсон боловч дулааны тоолуур ашиглаагүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.2-т "нэгдсэн халаалтын системд холбогдсон барилга байгууламжийг хэмнэлтийн горимд тохируулах, тоолуур ашиглах" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- ✓ Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих мэдээллээс түүвэрчилж үзэхэд 5 сая төгрөгөөс дээш зарлагын 5 гүйлгээний 40,447.5 мянган төгрөг, 5 сая төгрөгөөс дээш орлогын 16 гүйлгээний 288,030.5 мянган төгрөг, 6 тушаал шийдвэрийг шилэн дансанд мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3-т "тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан", 6.4.8-т "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй бүх төрлийн автотээврийн хэрэгсэлд бусад автотээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ", заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Авто тээврийн хэрэгсэлд тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэх Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ сая төгрөгөөр/												
Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Говь-Алтай аймгийн Дарив сумын Эрүүл мэндийн төв	3	125.3	-	-	3	125.3	3	125.3	-	-	-	-
Дүн	3	125.3	-	-	3	125.3	3	125.3	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
Говь-Алтай аймгийн Дарив сумын Эрүүл мэндийн төв	6	16.3	3	11.7	2	4.5	-	-	1	1	-	-
Дүн	6	16.3	3	11.7	2	4.5	-	-	1	1	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	/сая төгрөгөөр/							
	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй тогтоомжтой холбоотой зөрчил								

Говь-Алтай аймгийн Дарив сумын Эрүүл мэндийн төв	1	0.0	-	-	1	0.0	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Говь-Алтай аймгийн Дарив сумын Эрүүл мэндийн төв	5	49.9	-	-	4	49.9	1	-
Нийт дүн	6	49.9	-	-	5	49.9	1	-

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1	-	-	-	1	-	-
	НИЙТ	1	1	-	-	-	1	-	-